



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/92

Чингис хот

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь заалтууд, Засгийн газрын 2012 оны "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 222 дугаар, 2016 оны "Гэрээний загвар батлах тухай" 179 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй нутгийн захиргааны байгууллагын хамтран ажиллах гурван талт гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд болон нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОУИТБС/-ын дэд зөвлөлийг байгуулсугай.

2. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа Сумдад төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжийн болон нутгийн иргэний төлөөллийн оролцоог хангасан ОУИТБС-ыг хэрэгжүүлэх сумын дэд зөвлөлийг байгуулж, хэрэгжилтийг хангуулж, холбогдох мэдээллийг тухай бүр, тайланг улирал бүрийн эхний сарын 10-ны дотор аймгийн дэд зөвлөлд ирүүлж, ил тод нээлттэй ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/397 дугаартай "Дэд зөвлөл байгуулах тухай" захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010270

АЙМГИЙН ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэрэнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэрэнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
	Б.Магсаржав	Монголросцветмет ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөрийн УБУ-ийн захирал, /зөвшилцсөнөөр/
	А.Даваажав	Бэрх-Уул ХХК-ийн Гүйцэтгэх захирал, /зөвшилцсөнөөр/
	А.Сүхбаатар	Ахмад багш нарын холбооны тэргүүн, /ИНБ-ын төлөөлөл, зөвшилцсөнөөр/
	С.Ган-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч
Г.Батсайхан	Хэрлэн сумын ИТХ-ын төлөөлөлөгч, /зөвшилцсөнөөр/	